



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээс хүргэх зорилго бүхий хамтын ажиллагааны санамж бичгийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн үр дүнг 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн дотор газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Чинзориг/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110915

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 23 сарын 13 өдрийн  
82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Г.Чинзориг

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн  
технологи, инновацийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Б.Билгүүн

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн  
технологи, инновацийн хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн гишүүд:

Э.Бямбасүрэн

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн  
технологи, инновацийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ч.Болор-Эрдэнэ

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн  
технологи, инновацийн хэлтсийн мэргэжилтэн

З.Болормаа

Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны  
газрын мэргэжилтэн

Э.Энх-Амгалан

Хүний аюулгүй байдлын судалгааны төв төрийн бус  
байгууллагын Төлөвлөлт, мониторингийн ажилтан

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 23 сарын 13 өдрийн  
8.2 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД НЭГ ЦЭГЭЭС ХҮРГЭХ ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АХЛЫН ХЭСГИЙН  
УДИРДАМЖ

Зорилго:

Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээн дэх "Нэг цонх"-ны зарчмыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нэг төрийн албан хаагчтай харьцдаг зарчмыг тогтоож Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Хүний аюулгүй байдлын судалгааны төв төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа "Нэг цонхны үйлчилгээ" төслийн баримт бичигтэй танилцах
2. Төрийн түгжрэлгүй үйлчилгээ зорилтын хүрээнд хийж буй ажилтай уялдуулах
3. Хамтын ажиллагааны санамж бичгийн төсөл боловсруулах
4. Санамж бичгийг үзэглэх ажиллагааг зохион байгуулах

Хүрэх үр дүн:

1. Нэг цэгээс иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэр төрөл гарсан байна
2. Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшлээр хийлгэнэ

Хугацаа: 2013.03.12 - 2013.03.24